

Бичил уурхайн
төвийн
бүрэлдэхүүн
хэсгүүд



**Бичил уурхайн
талаар мэдээ
мэдээлэл**



Мэдээллийн сан
ном товхимол
нийтлэл
тайлан судалгаа
видео сан
зургийн сан



**Цахим
сургалт**




Сэдэвчилсэн бүлгүүд

- Бичил уурхайн бодлого ба хууль эрхзүй
- Хүний эрхэд суурилсан хандлага ба албажуулалт
- Эдийн засгийн тогтвортой байдал, нийлүүлэлтийн сүлжээ
- Байгаль орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд



**БИЧИЛ УУРХАЙН
МЭДЛЭГИЙН ТӨВ**



Мэдлэгийн
төвд хэрхэн
хувь нэмрээ
оруулах вэ?

Бичил уурхайн мэдлэгийн төвийн цахим платформыг хөгжүүлэх, бичил уурхайтай холбоотой мэдээ мэдээллээр хангахад хамтрагч байгууллагуудын идэвх санаачилга чухал ач холбогдолтой. Иймд байгууллагуудыг хамтран ажиллахыг урьж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг бидэнтэй холбогдон авах боломжтой.



Мэдлэгийн
төвийн түнш
байгууллагууд



**УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

Холбоо барих

Бичил уурхайн мэдлэгийн төв

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний
гудамж-5/2, Улаанбаатар, Монгол улс

Утас: (51)-263023

Факс: (11)-318169

Имэйл: info@asmhub.mn

Вэб хуудас: www.asmhub.mn

Facebook: ASM Mongolia

Twitter: ASM_Mongolia



БИЧИЛ УУРХАЙН МЭДЛЭГИЙН ТӨВ



www.asmhub.mn

Алсын хараа

Монголын хамтрагч талууд үндэсний ба олон улсын бичил уурхайн тэргүүн туршлагаудаас суралцах болон хувь нэмрээ оруулах

Зорилго

ШХА-ийн “Тогтвортой бичил уурхай” төсөл нь эдийн засгийн тогтвортой, байгаль орчны хариуцлагатай, хүний эрхэд суурилсан бичил уурхайн салбарыг Монгол Улсад төлөвшүүлэх, бичил уурхайгаар олборлосон алтны худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, бичил уурхай дахь дэлхийн бусад улс орны сайн туршлагыг нэвтрүүлэх, өөрсдийн туршлагаас хуваалцахад дэмжлэг үзүүлэх замаар Монгол Улсад “Бичил уурхайн Мэдлэгийн төв”-ийн цахим платформ хөгжүүлэх, бүтээхээр зорьж ажиллаж байна.

Энэхүү цахим платформ нь хамтрагч талууд мэдлэг, мэдээлэл олж авах, хуваалцах, суралцах, хадгалах хамгийн тохиромжтой суурь бааз бөгөөд нийгэм, байгаль орчны хариуцлагатай бичил уурхайн сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээхэд хувь нэмрээ оруулна.



Бичил уурхайн Мэдлэгийн төв гэж юу вэ?

Энэхүү платформ нь бичил уурхайн салбарын хамгийн сүүлийн үеийн мэдээллийг хадгалахаас гадна энэ салбарт зохион байгуулагдах арга хэмжээнүүдийн мэдээ мэдээллүүдийг байршуулна. Түүнээс гадна бичил уурхайн салбарын хамтрагчид мэдээ, мэдээлэл, судалгаа, товхимол, нийтлэлийг олон нийтэд хүргэх бөгөөд бичил уурхайн эрх зүйн орчин, мөнгөн ус ба химийн хорт бодисын асуудал, хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй, байгаль орчны асуудал, хүний эрх ба жендерийн асуудал, нийлүүлэлтийн сүлжээ ба эдийн засгийн хөгжил, бичил уурхайчид ба орон нутгийн удирдлага болон үр дүн, ололт, амжилт гэсэн 8 сэдвээр мэдээллүүдийг багтаасан. Цахим платформын Групп гэсэн хэсэг нь харилцан яриа, хэлэлцүүлэг, мэтгэлцээний гол цэг бөгөөд Сэдэвчилсэн дөрвөн бүлгийн гишүүд үүнийг үүсгэх боломжтой юм.

Платформ нь цахим сургалтын модультай бөгөөд бичил уурхайн үйл ажиллагааны бүртгэл, зохион байгуулалт болон албажуулалт, бичил уурхайчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчны талаар “хэрхэн, яаж” гэсэн асуултуудад хариулт өгнө. Мөн Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны 1900-2959 лавлах утасны үйлчилгээтэй холбогдож мэргэжилтнээс зөвлөгөө авах боломжтой.